# МОНГОЛ УЛСЫН
# ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 03 сарын 16 өдөр Дугаар 99 Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл олгох,
сэргээх, түдгэлзүүлэх тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.4, 15 дугаар зүйлийн 15.12.2, 15.12.3, 15.12.11, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын 2015 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байгууллагуудын нэрсийг нэгдүгээр, тусгай зөвшөөрлийн эрхийг сэргээсэн байгууллагын нэрийг хоёрдугаар, тусгай зөвшөөрлийн эрхийг түдгэлзүүлсэн байгууллагуудын нэрсийг гуравдугаар хавсралтаар тус тус батлагсугай.

2. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн эрхийг 3 сарын хугацаатай түдгэлзүүлсэн байгууллагуудад ажил сайжруулах хугацаатай үүрэг даалгаврыг албан бичгээр мэдэгдэх арга хэмжээ авч, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Б.Эрдэнэчимэг/-т үүрэг болгосугай.

3. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр авсан болон сэргээсэн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Б.Эрдэнэчимэг/, Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /О.Баяр/ нарт үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэнд, спортын дэд сайд /Д.Атармаа/-д даалгасугай.

САЙД Г.ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

080326

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 03 сарын 16 өдрийн
99 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОСОН БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ, ХУГАЦАА

| № | Байгууллагын нэр | Үйл ажиллагааны чиглэл | Тусгай зөвшөөрлийн хугацаа |
|---|---|---|---|
| 1 | Хаппидент сервис ХХК | шүдний эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж импортлох, ханган нийлүүлэх | 3 жил |
| 2 | Лаклайф Рич ХХК | биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх | 3 жил |
| 3 | Таны өмнөөс консалтинг ХХК | эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж импортлох, ханган нийлүүлэх | 3 жил |
| 4 | Отгонбуянт хүрээ ХХК | эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх | 3 жил |
| 5 | Одь тан ХХК | уламжлалт эм үйлдвэрлэх, эмийн түүхий эд импортлох | 3 жил |
| 6 | Сметс ХХК | эм импортлох, ханган нийлүүлэх | 3 жил |
| 7 | Айвико Интернэйшнл ХХК | Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм ханган нийлүүлэх | 3 жил |
| 8 | Апрель ХХК-ний Илизаров нэгдсэн эмнэлэг | гэмтэл согог, түлэгдэлт, нөхөн сэргээх, эрүү нүүр, арьс гоо засал, дотор, сэргээн засах, оношлогоо, яаралтай тусламж | 3 жил |

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 03 сарын 16 өдрийн
99 дугаар тушаалын 2 дугаар
хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ СЭРГЭЭСЭН БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ, ХУГАЦАА

| № | Байгууллагын нэр | Үйл ажиллагааны чиглэл | Тусгай зөвшөөрлийн хугацаа |
|---|---|---|---|
| 1 | Эвергүүд лайф ХХК | биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх | 3 жил |

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 03 сарын 16 өдрийн
99 дугаар тушаалын 3 дугаар
хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЭРХ ТҮДГЭЛЗҮҮЛСЭН БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ

| № | Байгууллагын нэр | Үйл ажиллагааны чиглэл |
|---|---|---|
| 1 | Арцны жимс ХХК | эмийн үйлдвэр |
| 2 | Эрдэнэбүрэн ХХК | эмийн үйлдвэр |
| 3 | Дентафарм ХХК | эмийн үйлдвэр |
| 4 | Уламжлалт, эм, эмийн ургамлын компани | уламжлалт эмийн үйлдвэр |
| 5 | Цаа-Од ХХК | эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх |
| 6 | Батчадунча ХХК | эмнэлгийн хэрэгсэл, нүдний контакт линз, дагалдах хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх |